



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 3 сарын 4 өдөр

Дугаар 4/42

Улаанбаатар хот

Хяналтын хуудас шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 479 дүгээр тогтоолын 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хяналт шалгалтад хэрэглэх Хөдөлмөрийн харилцааг шалгах 07.1.1 кодтой хяналтын хуудсыг нэгдүгээр, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах 07.1.2 кодтой хяналтын хуудсыг хоёрдугаар, Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах 07.2.1 кодтой хяналтын хуудсыг гуравдугаар, Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах 07.3.1 кодтой хяналтын хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Салбарын хяналтын газар (Б.Нарангарав), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (З.Энхболд), Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Хяналтын хуудсыг хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчид батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Х.БУЛГАНТУЯА

151240131

D: 2024 on 03 sar tushaal

[Handwritten signature]